



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/104

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Токио-2020 пара олимпийн эрх олгох олон улсын тэмцээнд оролцох Жаргалант сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэн Э.Гантулгын замын зардалд 950 000 төгрөгийг хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 950 000 төгрөг /Есөн зуун тавин мянган / -ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5. 19-д тусгагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг дэмжих” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/104 Ch  
02 00468

Аймгийн Засаг даргын 2020 оны  
02 дугаар сарын 18- ны өдрийн  
А/104 дүгээр захирамжийн хавсралт



Э.ГАНТУЛГЫН ЗАМЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Овог нэр	Албан тушаал	Замын зардал /төг/
1	Э.Гантулга	Тамирчин	950000
	Нийт		950000

-oOo-